

ТӨМӨР ЗАМААР ЗОРЧИГЧ, ТЭЭШ, АЧААН ТЭЭШ ТЭЭВЭРЛЭХ ДҮРЭМ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Энэхүү дүрмийн зорилго нь Төмөр замын тээврийн тухай хууль болон орон нутгийн тээвэрлэлттэй холбоотой бусад захиргааны хэм хэмжээний актад тулгуурлан зорчигч, тээш, ачаан тээшийг түргэн шуурхай, бүрэн бүтэн, аюулгүй байдлыг хангаж тээвэрлэхэд оршино.

1.2. Энэхүү дүрмээр тээвэрлэгч, зорчигч болон тээш, ачаан тээш илгээгч, хүлээн авагчийн эрх үүргийг тодорхойлох, хариуцлагын хязгаарыг тогтоох зэрэг харилцааг зохицуулна.

1.3. Энэхүү дүрмийг орон нутгийн зорчигч тээврийн харилцаанд оролцогч ажилтан, зорчигч болон тээш, ачаан тээш илгээгч, хүлээн авагч нарын үйл ажиллагаанд мөрдөнө.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

ЗОРЧИГЧ ТЭЭВЭРЛЭЛТ

Олон улсад мөрдөгдөж буй баримт бичгээс бусад Монгол Улсын нутаг дэвсгэрт зорчигч тээвэрлэлт гүйцэтгэх асуудлыг төмөр замын тээврийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага шийдвэрлэнэ.

2.1. Ерөнхий нөхцөл

2.1.1. Зорчигч тээвэрлэлтийн үйл ажиллагааг гүйцэтгэхдээ зорчигчдод үйлчлэх төвтэй байна. Хүн амын төвлөрөл багатай хэсгүүдэд зорчигчдод зориулсан хүлээлгийн танхим, гэрэлтүүлэг, тавцантай байна. Тасалбар борлуулах цэггүй бол цахимаар авч болно.

2.1.2. Төмөр замын суурь бүтцийн үйлчилгээ үзүүлэгч нь төмөр замын зорчигчид үйлчлэх төвийн орчны тохижилт, арчлалт, засвар, үйлчилгээг хариуцна.

2.1.3. Зорчигчид үйлчлэх төв нь тасалбар борлуулах газар, хүлээлгийн танхим, ариун цэврийн болон эх хүүхдийн, эрүүл мэндийн, нийтийн хэв журмыг сахиулах танхимтай байна.

2.1.4. Хөгжлийн болон хөдөлгөөний бэрхшээлтэй иргэдэд зориулсан шат, тусгай тоног төхөөрөмжтэй байх ба мэдээллийг бичвэр, дохио, цахим хэрэгслийг ашиглан хүргэх үйлчилгээ үзүүлэх нөхцөлийг бүрдүүлсэн байна.

2.1.5. Зорчигчдод үйлчлэх төв нь галт тэрэгний болон үйлчилгээний цагийн хуваарь, иргэдэд үзүүлэх үйлчилгээний газрын байршил, аюулгүйн гарц, бүдүүвч зураг, зорчигч, тээш, ачаан тээш тээвэрлэлтийн тариф, зорчигч болон тээш тээвэрлэлттэй холбоотой дүрэм, журам, заавар, цаг үеийн мэдээллийг нээлттэй байршуулсан байна.

2.1.6. Тасалбар борлуулах газрын ажиллах цагийн хуваарийг тээвэрлэгч тогтооно.

2.1.7. Галт тэрэг хөдлөхөөс 15 минутын өмнө тасалбар борлуулах ажиллагааг зогсоох бөгөөд байршлаас хамаарч энэхүү хугацааг өөрчилж болно.

2.1.8. Тээвэрлэгч нь зорчигчдод үйлчлэх төвийг тээвэрлэлтийн гэрээний үндсэн дээр ашиглаж болно.

2.1.9. Зорчих тасалбар нь тээвэрлэгч, зорчигч хооронд тээвэрлэлтийн гэрээ байгуулсаныг нотлох бичиг баримт бөгөөд батлагдсан маягтын дагуу бичигдсэн байна. Зорчих тасалбар нь цаасан болон цахим байж болно.

2.1.10. Насанд хүрээгүй буюу 18 наснаас доош насны хүүхдэд олон улсын зорчих тасалбар худалдаалахдаа итгэмжлэлийг заавал хавсаргана.

2.1.11. Зорчих тасалбарыг үндэслэн зорчигч тээвэрлэлтийн үйлчилгээг хялбар, шуурхай үзүүлнэ.

2.1.12. Тээвэрлэгч нь тасалбарт заасан суудлаар хангаж, хүрэх газарт хүргэх үүрэгтэй.

2.1.13. Тээвэрлэгч нь зорчих тасалбарыг тасалбар худалдаалах төв, цахим, автомат машин болон гэрээт борлуулагчаар дамжуулан худалдаалж болно.

2.1.14. Тээвэрлэгч нь зорчих тасалбарын дагуу зорчигчийг онцгой нөхцөл байдлаас шалтгаалан хүрэх газарт хүргээгүй бол тээврийн зардлыг буцаах эсхүл бусад төрлийн тээврийн хэрэгсэлээр тээвэрлэх үүрэгтэй.

2.1.15. Зорчигчдод үйлчлэх төвөөс нийтийн вагоны суудлын тооноос дээш 5-аас илүүгүй, тусдаа суудал эзлэхгүй тасалбар худалдаалж болно.

2.1.16. Тээвэрлэгч зорчигчдод тарифын хөнгөлөлт эдлүүлж болно.

2.1.17. Тасалбар буцаалтын суутгалын хувь хэмжээг тээвэрлэгч тогтооно.

2.1.18. Тээвэрлэгч нь зорчигчийг хоорондын замд зогсолттой өртөө, зөрлөгөөс зорчигчийн аль ч вагонд суулгана.

2.1.19. Тасалбарыг галт тэрэг аялахаас 1 сарын өмнө худалдана.

2.1.20. Тасалбарын батлагдсан маягтад зорчигчийн овог нэр, нууцлал бүхий регистрийн дугаар эсхүл иргэний бүртгэлийн дугаар, тээвэрлэгч, борлуулагчийн код, галт тэрэгний дугаар, вагон, суудлын дугаар, вагоны зэрэглэл, аялал эхлэх, дуусах, явах, хүрэх өртөө, тасалбар худалдаалсан огноо, цаг минут, тасалбарын үнэ, үйлчилгээний нэмэгдэл хураамж, зорчигчид зориулсан санамж зэрэг мэдээлэл агуулсан байна.

2.1.21. Зорчигч, тээш тээвэрлэлтийн аюулгүй байдлыг хангах зорилгоор зорчигчийн галт тэргийг өртөө, зөрлөгт зөвхөн зориулалтын замаар хүлээн авч явуулах бөгөөд зорчигчийн галт тэргийг хүлээн авах, явуулах зориулалтын зам нь үндэсний стандарт, төмөр замын тээврийн дүрэм, журмаар тогтоосон хэмжээний гэрэлтүүлэг, тавцан, талбайтай байна.

2.1.22. Хэрвээ тухайн зорчигчийн галт тэрэг цагийн хуваариар яваагүй эсхүл цуцлагдсан тохиолдолд уг Тээвэрлэгч нь энэ талаар зорчигчдод үйлчлэх төв, тасалбар түгээврийн цэгүүд болон олон нийтийн мэдээллийн хэрэгслээр дамжуулан нийтэд зарлана.

2.2. Тодорхойлолт

2.2.1. "тээвэрлэгч" гэж тээвэрлэлтийн гэрээний дагуу төмөр замаар зорчигч, ачаа, тээш, ачаан тээшийг тээвэрлэх үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээдийг;

2.2.2. "зорчигч" гэж төмөр замаар зорчиж байгаа зорчих тасалбар, түүнтэй адилтгах баримт бичигтэй хүнийг;

2.2.3. "аялал" гэж зорчигч хуваарийн дагуу тогтоосон чиглэлд эхлэхээс хүрэх өртөө хүртэлх хугацааг;

2.2.4. "тасалбар" гэж зорчигчийн ба тээшийн баримт бичиг эсхүл цахим тасалбарыг хэлэх бөгөөд энэ нь зорчигч, тээвэрлэгч хоёрын хооронд байгуулсан тээвэрлэлтийн гэрээ, түүний дотор тээвэрлэлтийн нөхцөлүүд, санамж байна;

2.2.5. "борлуулагч" гэж тээвэрлэгчийг төлөөлөхөөр гэрээ байгуулж, тасалбар борлуулах эрх олгосон хуулийн этгээдийг;

2.2.6. "тариф" гэж тээвэрлэгчийн олон нийтэд зарласан, хянагдсан, үнэ хураамж буюу түүнтэй холбогдох тээвэрлэлтийн нөхцөлүүдийг;

2.2.7. "бага насны хүүхэд" гэж харгалзах хүнтэй тав ба түүнээс доош насны хүүхдийг;

2.2.8. "хүүхэд" гэж хүүхдийн тарифаар зорчих таваас дээш арван хоёр /5-12/ насны хүүхдийг;

2.2.9. "ачаан тээш" гэж хүн, хуулийн этгээдээс тээшийн вагоноор тээвэрлүүлэхээр зохих журмын дагуу хүлээлгэн өгсөн эд зүйлсийг;

2.2.10. "тээш" гэж тээшийн вагоноор тээвэрлүүлэхээр зохих журмын дагуу хүлээлгэн өгсөн зорчигчийн эд зүйлсийг;

2.2.11. "аюултай ачаа" гэж төмөр замын тээвэрлэлт, ачилт, буулгалт, хадгалалтын явцад хүний эрүүл мэнд, мал, амьтан, хүрээлэн байгаа орчинд хор хөнөөл учруулах, тээврийн хэрэгсэл, техник, тоног төхөөрөмж, барилга байгууламжид эвдрэл, гэмтэл үүсгэх, улмаар тэсэрч, дэлбэрэх, шатах шинж чанартай, үхэл, хордлого, түлэгдэлт, өвчин, осол үүсгэж болзошгүй химийн бодис, бүтээгдэхүүн, эд зүйлсийг;

2.3. Тасалбарын хүчинтэй хугацаа

2.3.1. Зорчих тасалбар нь тухайн галт тэргэнд аялал эхлэх өртөөнөөс дуусах өртөө хүртэл, тэмдэглэгдсэн хугацаанд, хүчинтэй байна. Аяллын хугацааг сунгаж болно.

2.3.2. Хэрэв зорчигч өвчний улмаас тасалбарын хүчинтэй хугацаанд цааш аялах боломжгүй болсон тохиолдолд зорчигчийн аялал зогссон цэгээс төлөгдсөн тарифын үйлчилгээний ангилалд суудал байгаа нөхцөлд зорчигч цааш аялах боломжтой болох өдөр хүртэл тасалбарын хугацааг сунгаж болох ба хураамж нь тарифын нөхцөлөөр зохицуулагдана.

2.4. Зорчигчийн эрх, үүрэг

2.4.1. Зорчигч нь нийтийн вагонд тусдаа суудал эзлүүлэхгүй гурваас илүүгүй бага насны хүүхдэд үнэ төлбөргүй тасалбар авч зорчино.

2.4.2. Тасалбарын хүчинтэй хугацаанд үнийг буцааж авах, хугацааг өөрчлөх хүсэлтээ цахимаар болон тасалбар борлуулах газарт хандана.

2.4.3. Тасалгаат болон унтлагын вагонд зорчигч өөрөө хүсвэл суудал эзлүүлэхгүйгээр 1 /нэг/ хүүхдийг хөнгөлөлттэй үнээр авч явна.

2.4.4. Аяллын явцад сул суудал байгаа тохиолдолд зорчигч өөрийн хүсэлтээр явах чиглэлийн дагуу вагоны зэрэглэл ахиулан, тогтоосон тарифын зөрүүг төлж зорчиж болно.

2.4.5. Зорчигчийн галт тэрэг нь шилжин суух өртөөнд батлагдсан хуваариас хоцорч ирсэн тохиолдолд дараагийн аяллаа үргэлжлүүлэхээр тасалбарыг нэг удаа сунгуулна.

2.4.6. Зорчих тасалбарт заасан суудлыг аяллын хугацаанд эзэмшинэ.

2.4.7. Харгалзах хүнгүйгээр хүүхэд зорчихыг хориглоно.

2.4.8. Зорчих тасалбар гэсэн, гэмтээсэн бол тээвэрлэгчид нотлох баримт бүрдүүлэн нэмэлт хураамж төлснөөр нөхөн авна.

2.4.9. Бусдын тасалбараар зорчсон тохиолдолд хүчингүйд тооцох бөгөөд дахин тасалбар авна.

2.4.10. Тасалбар худалдаж авах, галт тэргэнд суух, аяллын явцад тасалбар шалгах эрх бүхий ажилтанд нотлох бичиг баримтаа шалгуулна.

2.4.11. Аяллын явцад нийтийн хэв журмыг сахин биелүүлэх, бусдын эдхөрөнгөнд хохирол учруулахгүй байна.

2.4.12. Галын аюулгүй байдлыг хангана.

2.4.13. Зорчигч галт тэргэнд аюултай ачаа биедээ авч явахыг хориглоно.

2.4.14. Зорчигч цагаан хэрэглэлийг буух өртөөнд хүрэхээс 50 минутын өмнө хураалгана.

2.4.15. Цагаан хэрэглэлийг үрэгдүүлсэн буюу бохирдуулсан тохиолдолд зорчигч нь үнийн дүнгээр тооцож төлнө.

2.4.16. Зорчигч аяллын хугацаанд гэнэтийн ослын даатгалд даатгуулна.

2.5. Тээвэрлэгчийн эрх, үүрэг

2.5.1. Дараах тохиолдолд тээвэрлэхээс татгалзах эрхтэй:

2.5.1.1. Галт тэргэнд сул суудалгүй үед;

2.5.1.2. Иргэний үнэмлэх түүнтэй адилтгах баримт бичиггүй;

2.5.1.3. Харгалзах хүнгүйгээр биеэ авч явах чадамжгүй, согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсэн, сэтгэцэд нөлөөлөх мансууруулах бодис хэрэглэсэн зорчигчийг;

2.5.1.4. Зорчих тасалбаргүй, тогтоосон овор, хэмжээнээс хэтэрсэн гар тээштэй зорчигчийг;

2.5.2. Зорчигчийн вагонд захиалагт эсхүл гэрээнд заасан бусад үйлчилгээг хэрэгжүүлж болно

2.5.3. Аялал жуулчдад зориулан зорчигчийн вагоныг түрээслэж болно.

2.5.4. Тусгай үйлчилгээ болон тоноглолтой вагоныг түрээслэж болно.

2.5.5. Зорчигчийн галт тэргийг утасгүй интернетээр хангаж болно.

2.5.6. Зорчигчийн галт тэрэгний цуваанд вагон-ресторан болон буфетээр үйлчилж болно.

2.5.7. Зорчигчийн галт тэргэнд тээш, ачаан тээшийн вагон холбож явуулна.

2.5.8. Нийтээр амрах баярын өдрүүд болон зорчигч урсгал нэмэгдэх үед нэмэлт зорчигчийн галт тэрэг, вагоноор үйлчилнэ.

2.5.9. Галт тэрэг болон сэлгээний хөдөлгөөний үед зорчигчийн аюулгүй байдлыг хангах зорилгоор сэрэмжлүүлэн зарлан мэдээлнэ.

2.5.10. Зорчигчийн галт тэрэгний бүрэлдэхүүнд албан хэрэгцээнд зориулсан тусгай вагон болон хувийн эзэмшлийн вагоныг гэрээний үндсэн дээр холбож болно.

2.5.11. Зорчигчийн галт тэргэнд батлагдсан жагсаалтын дагуу нэмэлт үйлчилгээ үзүүлнэ. /үүнд: цай, кофе, цэвэр ус, буцалсан ус, хоол хүргэлт, ахуйн хэрэгцээний зүйлс гэх мэт/

2.5.12. Өвчтэй болон хүндэтгэн үзэх шалтгаан /нас барсан/-ы улмаас зорчигч аяллаа үргэлжлүүлэх боломжгүй тохиолдолд аялаагүй зайн тасалбарын тарифын зөрүүг буцааж олгоно.

2.5.13. Хууль, хяналтын байгууллага шаардсанаас бусад тохиолдолд зорчигчдын мэдээллийн нууцыг хадгална.

2.5.14. Галт тэргэнд зорчигчдод зориулж өртөөг мэдээлэх самбартай байна.

2.5.15. Тасалгаат болон унтлагын вагонд зорчигчийг цагаан хэрэглэлээр хангаж болно.

2.5.16. Тээвэрлэгчийн буруугаас зорчигчийг вагоны зэрэглэлийг бууруулсан тохиолдолд зорчих тасалбарын тарифын зөрүүг буцааж олгоно. Энэ тохиолдолд тээвэрлэгчийн төлөөлөл шаардлагатай туслалцаа үзүүлэх ба зорчигчдын аюулгүй байдлыг хангах урьдчилсан арга хэмжээг авсан байвал зохино.

2.5.17. Аяллын явцад согтуурсан, мансуурсан эсхүл сэтгэцийн хүнд өвчтэй зорчигч нийтийн амгалан тайван байдлыг алдагдуулсан бол нийтийн хэв журмыг хангах арга хэмжээ авна.

2.5.18. Аяллын явцад нийтийн ариун цэврийн өрөөг тохь тухтай, тогтмол цэвэрлэж, ариутгал хийж байна. Үндсэн өртөөн дээр нийтийн ариун цэврийн өрөөг түр хаана. Вакум буюу бохироо гадагшаа хаядаггүй ариун цэврийн өрөөтэй бол аяллын туршид нийтийн ариун цэврийн өрөөг тогтмол нээлттэй байлгана.

2.5.19. Аяллын явцад тасалбар авахаас татгалзвал цагдаагийн ажилтанд хүлээлгэн өгч, учирсан хохирлыг барагдуулах арга хэмжээ авна.

2.6. Тээвэрлэлтийн гэрээ

2.6.1. Тээвэрлэлтийн гэрээ нь нэг талаас үйлчлүүлэгч байгууллага, иргэн нөгөө талаас Тээвэрлэгч эсхүл борлуулагч хооронд байгуулсан гэрээг төлөөлөх баримт бичгээр баталгаажна.

2.6.2. Тээвэрлэгч нь зорчигч тээвэрлэлтийн гэрээгээр зорчигч, түүний тээшийг гэрээнд заасны дагуу тээвэрлэх, гэрээнд өөрөөр заагаагүй бол зорчигч нь тээвэрлэлтийн төлбөрийг тогтоосон тарифын дагуу төлөх үүргийг хүлээнэ.

2.6.3. Тээвэрлэгч нь тээш, ачаан тээш тээвэрлэлтийн гэрээгээр илгээгчийн ачааг гэрээнд заасны дагуу тээвэрлэх, хүлээн авагчид хүлээлгэн өгөх, гэрээнд өөрөөр заагаагүй бол илгээгч нь тээвэрлэлтийн төлбөрийг тогтоосон тарифын дагуу төлөх үүргийг хүлээнэ.

2.6.4. Тээвэрлэгч нь тээвэрлэлтийн гэрээг төлөөлөх баримт бичигт тээвэрлэлтийн гэрээний нөхцөлийг тусгасан байна. Хэрэв гэрээний нөхцөлийг бүрэн тусгаагүй бол энэ дүрэмд шаардсаны дагуу нэмэлт мэдээллээр зорчигч болон ачаа илгээгчийг хангах үүрэгтэй.

2.6.5. Тээвэрлэгч нь тээвэрлэлтийн гэрээний нөхцөлийн талаарх мэдээллээр хангах үүрэгтэй.

2.7. Зорчигчдод хөнгөлөлт үзүүлэх

2.7.1. Оюутан, сурагчид, олон улсын чанартай уралдаан тэмцээн, хүүхдийн зусланд амрахаар зорчих албан хүсэлт гаргасан тохиолдолд зохион байгуулалттайгаар орон нутгийн зорчигчийн галт тэргээр зорчиход тарифын хөнгөлөлт үзүүлж болно. Тарифын хөнгөлөлт ба түүний хэмжээг тээвэрлэгч тогтооно;

2.7.2. Олон улс болон орон нутгийн зорчигчийн галт тэргээр зорчих жуулчид зорчигчдод үйлчлэх төвд урьдчилан захиалга өгч болно;

2.7.3. Бүлгээрээ (6-аас дээш) зорчихоор хүсэлт ирүүлсэн хөгжлийн бэрхшээлтэй болон хүнд өвчтэй зорчигчдод галт тэргээр зорчих, вагон түрээслэхэд тарифын хөнгөлөлт үзүүлж болно

2.7.4. Нийгмийн хариуцлагын хүрээнд хүмүүнлэгийн туслалцаа, үйлчилгээ үзүүлэх зорилгоор вагоныг түрээслэхэд тарифын хөнгөлөлт үзүүлж болно.

2.8. Хөгжлийн болон хөдөлгөөний бэрхшээлтэй зорчигчийг тээвэрлэх

2.8.1. Тээвэрлэгч нь хөгжлийн болон хөдөлгөөний бэрхшээлтэй иргэдийг зорчиход зориулсан өргөх төхөөрөмж, тавцан, шат, орц, гарцын байрлал болон бусад шаардлагатай мэдээллээр хангана;

2.8.2. Хөгжлийн болон хөдөлгөөний бэрхшээлтэй иргэнд тасалбар захиалах болон худалдах үйлчилгээ үзүүлэхдээ дараалал харгалзахгүй шуурхай үйлчилнэ. Мөн зориулалтын зам талбай, хүлээлгийн танхимаар шуурхай үйлчилгээ үзүүлнэ;

2.8.3. Хөгжлийн болон хөдөлгөөний бэрхшээлтэй зорчигч нь туслах хэрэгсэл /тэргэнцэр, таяг гэх мэт/-ийг үнэ төлбөргүй тээвэрлэнэ;

ГУРАВДУГААР БҮЛЭГ

ГАР ТЭЭШ ТЭЭВЭРЛЭХ, ХАДГАЛАХ

3.1. Гар тээш тээвэрлэх

3.1.1. Гар тээшинд зорчигч аяллын туршид хэрэглэх хүнсний болон хувийн хэрэгцээний эд зүйлс, ариун цэврийн хэрэглэл, ахуйн зориулалттай барааг авч явна.

3.1.2. Зорчигч нь зорчих тасалбараар 40х60х80см-ээс хэтрэхгүй хэмжээтэй 36 кгаас илүүгүй жинтэй /бага насны болон хүүхдийн тасалбараар 15 кг хүртэл жинтэй/ гар тээшийг үнэ төлбөргүй авч явах эрхтэй;

3.1.3. Гар тээш нь вагоны зориулалтын байранд хялбар багтах, бусад зорчигчдод саад болохооргүй байна;

3.1.4. Гар тээшийн бүрэн бүтэн байдлыг зорчигч өөрөө хариуцах үүрэгтэй;

3.1.5. Бага насны хүүхдийн хамт зориулалтын тэрэг болон бусад хэрэглээний эд зүйлсийг үнэ төлбөргүй тээвэрлэнэ;

3.1.6. Хорио цээр тогтоосон бүс нутгаас гар тээш тээвэрлэхийг хориглох ба зайлшгүй тохиолдолд холбогдох эрх бүхий байгууллагын зөвшөөрлийн үндсэн дээр гүйцэтгэнэ;

3.1.7. Зорчигч нь бусдын эд зүйлсийг гэмтээх, бохирдуулах, түүхий мах, түргэн муудах, эвгүй үнэртэй бүтээгдэхүүн зэргийг гар тээшинд авч явахыг хориглоно. Дээрх зүйлсийн улмаас вагон болон бусдад хохирол учруулбал хариуцлага хүлээж, хохирлыг барагдуулна;

3.2. Гар тээш хадгалах

3.2.1. Зорчигчдод үйлчлэх төв нь гар тээш хадгалах цэгтэй байна. Гар тээш хадгалах цэгийн ажиллах цагийн хуваарийг тээвэрлэгч тогтооно;

3.2.2. Гар тээш хадгалах байранд нэг байр нь 50 кг-аас дээшгүй жинтэй, 3-н хэмжээсийн нийлбэр нь 200 см-ээс хэтрэхгүй сав, баглаа, боодолтой тээшийг байр тус бүрээр нь хүлээн авч хадгална.

3.2.3. Гар тээшинд түргэн муудах, гэмтэх эд юмсыг хадгалуулахгүй.

3.2.4. Хадгалах цэгт гар тээш хүлээн авахдаа биеийн байцаалтыг үндэслэн сав, баглаа, боодлын бүрэн бүтэн байдлыг шалгаж, хадгалах үйлчилгээ үзүүлнэ.

3.2.5. Гар тээш хадгалуулсны төлбөрийг тогтоосон тарифын дагуу төлнө.

3.2.6. Хадгалуулсан гар тээшийн дагалдах бичгийг зорчигч үрэгдүүлсэн тохиолдолд өөрийн эд зүйл болохыг нотлох бөгөөд түүнийг хянан үзсэний үндсэн дээр олгож болно.

3.2.7. Гар тээшийг 5 хүртэлх хоногийн хугацаатайгаар хадгалах цэгт хүлээн авна. Гар тээшийг хадгалах хугацааны талаар мэдээлэл өгөх ба 30 хоногийн дотор аваагүй тохиолдолд тээвэрлэгч комисс томилон уг гар тээшийг Иргэний хууль болон бусад хууль тогтоомжийн дагуу зохион байгуулна.

3.2.8. Зорчигчдод үйлчлэх төвд гар тээш хадгалах автомат хайрцгуудыг байрлуулж болно. Энэ тохиолдолд ашиглах зааврыг олон нийтэд үзэгдэхүйц газар байрлуулна;

3.2.9. Гар тээш хадгалуулагч нь автомат хайрцагны нууц дугаарын хадгалалт, ашиглалтыг зөвхөн өөрөө хариуцна;

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

ТЭЭШ, АЧААН ТЭЭШ ТЭЭВЭРЛЭЛТ

4.1. Ерөнхий нөхцөл

4.1.1. Тээвэрлэгч нь зорчигч болон илгээгчээс тээш, ачаан тээшийг хүлээн авч төмөр замын өртөө /уг ажиллагаанд нээлттэй/ хүртэл тээвэрлэх үүрэгтэй.

4.1.2. Тээш, ачаан тээшийн төлбөрийн баримт нь тээвэрлэлтийн гэрээ байгуулсныг нотлох бичиг баримт болно. Ачаан тээш тээвэрлэхэд зорчигчийн тасалбар шаардахгүй.

4.1.3. Тээвэрлэгч нь илгээгчийн тээш, ачаан тээшийг тээшийн вагон холбогдсон хамгийн эхний галт тэргээр тээвэрлэнэ.

4.1.4. Тээшийг зорчигчийн зорчиж байгаа галт тэргээр эсхүл тээшийн вагон холбогдсон эхний галт тэргээр тээвэрлэнэ.

4.1.5. Тээвэрлэлтэд хүлээлгэн өгч байгаа тээш, ачаан тээш нь хэмжээ, сав, баглаа боодол, шинж чанарын хувьд тээшийн вагонд ачиж буулгахад хүндрэл үүсгэхгүй, тээвэрлэгчийн эд зүйл, бусад зорчигчийн тээш, ачаан тээшийг гэмтээхээргүй байна.

4.1.6. Тээш, ачаан тээш тээвэрлэх гэрээний дагуу тээвэрлэгч нь тээш, ачаан тээшийг хүрэх газарт хүргэх бөгөөд зорчигч, илгээгч үйлчилгээний төлбөрийг төлөх үүрэгтэй.

4.1.7. Тээвэрлэлтийг хэд хэдэн тээвэрлэгч гүйцэтгэсэн тохиолдолд тэдгээр нь тээш илгээгч, эсхүл тээш хүлээн авагчийн өмнө тээш, ачаан тээшийг үрэгдүүлсэн, дутаасан, гэмтээж муутгасан болон хүргэх хугацааг нь хожимдуулсны хамтын хариуцлага хүлээнэ.

4.1.8. Хэрэв өөр тээвэрлэгч, тээш илгээгч, тээш хүлээн авагч, салбар зам эзэмшигч, тээвэр зуучлагчийн буруугаас үүссэн хариуцлагыг тээвэрлэгч хүлээсэн бол хохирлоо буруутай этгээдээс шаардах эрхтэй.

4.1.9. Тээвэрлэгч нь тээш, ачаан тээшийг тээвэрлэлтэд хүлээн авсан мөчөөс хүлээн авагчид олгох үе хүртэл түүний бүрэн бүтэн байдлыг хангах үүрэгтэй.

4.1.10. Тээш, ачаан тээшийг тээвэрлэлтэд хүлээлгэн өгөхдөө үнэ зарлаж болно.

4.1.11. Үнэ зарлаж тээвэрлэлтэд хүлээн авсан тээш, ачаан тээшийг алдаж үрэгдүүлсэн, дутаасан, гэмтээж муутгасан бол тээвэрлэгч зарласан үнийн хэмжээгээр хариуцлага хүлээнэ.

4.1.12. Тээш, ачаан тээшийг зорчигч, илгээгч нь тээвэрлэхийг хориглосон, аюултай ачааг тээвэрлэхийг хориглоно.

4.1.13. Зорчигч, илгээгч нь тээш, ачаан тээшийг Монгол Улсын хуулиар хориглосон ачаа ачих, ачаанд нуухыг хориглоно.

4.1.14. Тээвэрлэгч тээш, ачаан тээш гэмтсэн, үрэгдсэн тохиолдолд ерөнхий маягтын акт тогтооно.

4.1.15. Тээвэрлэгч нь тээвэрлэлтийн бичиг баримтад ерөнхий маягтын акт тогтоосон тэмдэглэгээг заавал үйлдэх үүрэгтэй.

4.1.16. Гомдлыг хүлээн авахаас бүрэн болон хэсэгчлэн татгалзсан, эсхүл гомдлыг судлах хугацаанд тээвэрлэгч хариу өгөөгүй бол тээвэрлэгчид холбогдуулан шүүхэд нэхэмжлэл гаргаж болно.

4.1.17. Тээш, ачаан тээшийн дагалдах бичгээ үрэгдүүлсэн тохиолдолд түүний бичгэн мэдүүлэг болон бусад холбогдох бичиг баримтыг үндэслэн уг тээш илгээгчийнх болохыг нотлох баталгааг гаргуулснаар олгож болно.

4.1.18. Тээвэрлэгч тээш, ачаан тээшийн зарласан үнэ зөв эсэхэд эргэлзвэл тээшийг задлахыг шаардаж болно. Ачаа илгээгч тээш, ачаан тээшээ задлахыг эс зөвшөөрвөл тээвэрлэхээс татгалзана.

4.1.19. Тээш, ачаан тээшийг тухайн зорчигчийн аялах галт тэргээр илгээх ба боломжгүй тохиолдолд дараагийн галт тэргээр эхний ээлжинд явуулна;

4.1.20. Мал адгуус болон зэрлэг амьтдыг тээш, ачаан тээшээр тээвэрлэхгүй.

4.1.21. Ачаан тээш ирсэн өртөөнд тээвэрлэгч нь ачаан тээш хүлээн авагчид харилцаа холбооны хэрэгслээр мэдэгдэж баримтжуулан тэмдэглэгээ хийнэ. Хүлээн авагчтай холбогдож чадаагүй тохиолдолд ачаан тээш илгээгчид мэдэгдэнэ.

4.1.22. Тээвэрлэлтэд хүлээж авсан ачаан тээш нь гадна үзлэгээр ямар нэгэн гэмтэл учраагүй, анхааруулах тэмдэггүйгээр хялбар муудах зүйлс /мах, сүү, ногоо, жимс

г.м./ хагарч эвдрэх хэврэг ачаа /шил, шаазан эдлэл, телевизор г.м./ нь гэмтсэн байвал тээвэрлэгч хариуцахгүй.

4.2. Тээш, ачаан тээшийг хадгалах

4.2.1. өртөөнд ирүүлсэн тээш, ачаан тээшийг ирсэн өдрөөс эхлэн тээш хүлээн авагчид олгох хүртэлх хугацаанд хадгалсан төлбөрийг тээвэрлэгчийн тогтоосон тарифын дагуу тээш хүлээн авагчаас авна.

4.2.2. Тээш, ачаан тээш хүлээн авагчид мэдэгдээд 30 хоногийн дотор аваагүй бол комисс томилон уг тээш, ачаан тээшинд Иргэний хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийн дагуу зохих арга хэмжээ авна. Хэрэв 30 хоногоос хэтэрч шинж чанараа алдаж, хадгалах боломжгүй болсон хүнсний бүтээгдэхүүнийг комиссын дүгнэлтийг үндэслэн устгалд оруулна.

ТАВДУГААР БҮЛЭГ

ТЭЭШ ХҮЛЭЭН АВАХ, ТЭЭВЭРЛЭХ, ОЛГОХ

5.1. Тээш хүлээн авах

5.1.1. Зорчигчийн галт тэрэгний зогсолттой болон тээш тээвэрлэлтэд нээлттэй бүх өртөө, зөрлөгт тээш хүлээн авах, тээвэрлэх, олгох ажиллагаа явагдана;

5.1.2. Зорчигчоос хүлээн авах тээш нь тээшийн вагоны хаалгаар чөлөөтэй багтах, ачих, буулгах, зөөвөрлөхөд хялбар бариултай, сав, баглаа, боодол нь тээвэрлэлтийн явцад тээшийн бүрэн бүтэн байдлыг найдвартай хангахаар бэлтгэгдсэн байвал зохино;

5.1.3. Задарч эвдрэхээргүй унадаг дугуй, хүүхдийн тэрэг, хөгжлийн болон хөдөлгөөний бэрхшээлтэй иргэний тэргэнцэр зэргийг сав, баглаа, боодолгүйгээр тээвэрлэлтэнд хүлээн авч болно. Эдгээрийн тоноглол бүхий жижиг хэрэгслийн бүрэн бүтэн байдлыг тээш илгээгч хариуцна;

5.1.4. Тээшний сав, баглаа, боодол нь бат бэх гэмтэлгүй байх шаардлага хангасан байна;

5.1.5. Нэг байр тээш нь 75 кг-аас ихгүй байна;

5.1.6. Тээш нь бусдын тээшинд гэм хор учруулах, бохирдуулах, эвгүй үнэртэй ачаа болон аюултай ачаа, хууль тогтоомжоор тээвэрлэхийг хориглосон зүйлс, мөн түүнчлэн хорио цээрийн голомтод байсан тэжээвэр амьтан, тээшийг тээвэрлэхээр хүлээн авахгүй.

5.1.7. Зорчигчийн зорчих тасалбарт заасан өртөө хүртэл тээшийг тээвэрлэх бөгөөд хүлээн авах цэгийн байрлалаас хамаарч галт тэрэг хөдлөхөөс хоёр цагийн өмнө тээшийг тээвэрлэлтэд хүлээн авна;

5.1.8. Онцгой болгоомж шаардсан тээшийг тээвэрлэлтийн гэрээ хийхдээ талууд техникийн нөхцөл, тээвэрлэлтийн шаардлагыг харилцан тохиролцон, зохих ачааны анхааруулах тэмдэгийг нааж хүлээн авна.

5.2. Тээш тээвэрлэх

5.2.1. Тээшний эзний буруутай үйл ажиллагаанаас үүсэх хохирлыг тээвэрлэгч хариуцахгүй. Хагарч эвдрэх ачааны тэмдэг наасан тээшийг гэмтээвэл тээвэрлэгч хариуцна;

5.2.2. Тээш хүлээн авах, олгох газар нь үйлчлүүлэгч нарт үйлчилгээ үзүүлэх боломжоор хангагдсан байна;

5.2.3. Зорчигчийн тээвэрлүүлэх тээш тус бүр дээр шошго наасан байна;

5.2.4. Тээшийг тээвэрлэлтэд хүлээн авч, тээшийн тасалбарын нэг хувийг илгээгчид өгнө.

5.2.5. Зорчигч тээшээ тээвэрлэлтэд хүлээлгэн өгөхдөө түүнд үнэ зарлаж болох ба зохих төлбөрийг тогтоосон тарифын дагуу төлнө. Хэд хэдэн тээш өгсөн бол тээш тус бүрд эсвэл нийтэд нь үнэ зарлаж болно. Тээш илгээгчийн зарласан үнийн дүн болон жинг тээшийн тасалбарт бичнэ;

5.2.6. Гэрчилгээтэй гэрийн тэжээвэр амьтан, шувууг шилжүүлэн тээвэрлэх нөхцөлгүйгээр хүлээн авна;

5.2.7. Гэрийн тэжээвэр амьтан, шувуу, ургамал, суулгац нь бусад тээш болон вагоныг гэмтээхгүй, бохирдуулахгүй байх боломжоор хангасан тусгай зориулалтын савтай хүлээн авч, галт тэрэг хөдлөхөөс нэг цагийн өмнө тээвэрлэлтэд хүлээн авна. Тусгай зориулалтын нэг савтай амьтан, шувуу, ургамал, суулгац /2 м-ээс бага/ нь 50 кг-аас хэтрэхгүй байна.

5.2.8. Гэрийн тэжээвэр амьтан, шувууг хооллох арчлах ажлыг тээш илгээгч хариуцна;

5.2.9. Гэрийн тэжээвэр амьтан, шувууг хүлээн авагч болон илгээгч хүрэх өртөөнд аваагүй тохиолдолд тээвэрлэгч цахим болон бусад хэлбэрээр мэдэгдэнэ;

5.2.10. Тээш илгээгч болон хүлээн авагч нь тээшээ аваагүй болон татгалзсан тохиолдолд холбогдох байгууллагад мэдэгдэнэ.

5.2.11. Тээшийн тасалбараа үрэгдүүлсэн тохиолдолд өөрийн эд зүйл болохыг нотолсон бичиг баримтыг үндэслэн олгож болно.

5.2.12. Гэрийн тэжээвэр амьтан, шувууг нэг илгээлтээр таваас /5/ ихгүйг тээвэрлэнэ.

5.2.13. Хууль, хяналтын байгууллагын шийдвэрээр тээшийг хүргэх өртөөнөөс өөр өртөөнд саатуулах бол баримтжуулан тэмдэглэгээ хийж, тээш илгээгч, хүлээн авагчид мэдэгдэнэ.

5.2.14. Эрүүл мэндийн байгууллага, бусад холбогдох баримт бичгийг үндэслэж битүүмжлэгдсэн хайрцагтай шарил, чандарыг хүлээн авч тээшийн вагонд тээвэрлэнэ.

5.3. Тээш олгох

5.3.1. Зорчигч аяллын явцад тээшээ авахыг хүсвэл тээвэрлэгчийн ажилтанд урьдчилан мэдэгдэнэ;

5.3.2. Тээш олгохдоо тээшийн тасалбарыг үндэслэн олгоно.

5.3.3. Тээш нь хүрэх өртөөнд ирээгүй тохиолдолд илгээгчид нэн даруй мэдэгдэж тасалбар дээр "тээш ирээгүй" гэсэн тэмдэглэл хийнэ;

5.4. Тээш гэмтэх, алга болох

5.4.1. Хүлээн авагч тээшийн тоо ширхэг, жин дутсан эсхүл сав, баглаа, боодол нь эвдэрсэн байхад хүлээн авахыг зөвшөөрвөл тээшийг олгож, дагалдах бичгийг тээшийн пүүлэгчид өгөх ба замын хүснэгтийн ард "өөрөө авахыг хүсэв" гэж тэмдэглэл хийж хүлээн авагчаар гарын үсэг зуруулна. Бусад тохиолдолд дутагдал, эвдрэлийн тухай түүний овог нэр, хаяг, үнэ зарласан байвал үнийн дүн зэргийг тусгасан ерөнхий маягтын дагуу акт тогтоох ба хуулбарыг түүнд өгнө;

5.4.2. Тээвэрлэгчийн буруугаас тээш алга болсон бол илгээгчийн хохирлыг Иргэний хуулиар зохицуулна.

ЗУРГААДУГААР БҮЛЭГ

АЧААН ТЭЭШ ХҮЛЭЭН АВАХ БА ТЭЭВЭРЛЭХ НӨХЦӨЛ

6.1. Ачаан тээш хүлээн авах

6.1.1. Ачаан тээш тээвэрлэхэд нээлттэй өртөөдөд ачаан тээш хүлээн авах, явуулах, олгох үйл ажиллагаа хийгдэнэ.

6.1.2. Ачаан тээш илгээгч, хүлээн авагчийн овог нэр, иргэний нууцлалтай регистрийн болон бүртгэлийн дугаар, хаяг, утасны дугаар, ачаан тээшний нэр, нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн тэмдэг, тэмдэглэгээ, зарласан үнэ, сав, баглаа, боодлын тоо, төрөл, хүндийн жин, тээвэрлэлтэд хүлээн авсан огноо, явуулах, хүрэх өртөөний нэр, тухайн барааг худалдан авсан үнэ, тээшийн жин, байрын тоо бичигдэнэ.

6.1.3. Нэг ачаан тээшийн хүндийн жин 200 кг хүртэл байж болох ба тээшийн вагоны хаалгаар саадгүй ачааг ачаан тээш тээвэрлэлтэд хүлээн авна. Хэрэв тухайн илгээгч болон хүлээн авагч өөрөө хүсвэл ачаан тээшээ аюулгүй ачиж, буулгаж болно.

6.1.4. Тээвэрлэгч нь ачаан тээш илгээгчид төлбөр төлсөн тээшийн тасалбар олгоно.

6.1.5. Ачаан тээш илгээгч нь ачаан тээшиндээ үнэ зарлаж болно. Тээврийн хөлс ба үнэ зарласан хураамжийг тарифт заагдсаны дагуу төлнө.

6.2. Ачаан тээш тээвэрлэх

6.2.1. Түргэн муудах хүнсний бүх төрлийн бүтээгдэхүүнийг, ачаан тээшийн вагонд тээвэрлэхээр хүлээн авахдаа илгээгчийн хүсэлтийн дагуу тээвэрлэх хугацаа, зайг гэмтэж муудахгүй тээвэрлэгдэх боломжтой эсэхийг тооцож хүлээн авна.

6.2.2. Түргэн муудах хүнсний бүх төрлийн бүтээгдэхүүн нь гэрээт хугацаанд хүргэгдсэн боловч тээвэрлэгчээс шалтгаалаагүй шинж чанараа алдсан тохиолдолд тээвэрлэгч хариуцахгүй;

6.3. Ачаан тээш олгох

6.3.1 Албан байгууллага, компанийн нэр дээр ирсэн ачаан тээшийг хүлээн авах этгээд нь тухайн байгууллагын итгэмжлэгдсэн төлөөлөл иргэний үнэмлэх эсвэл нотлох бичиг баримтыг үндэслэж олгоно.

ДОЛДУГААР БҮЛЭГ

ТЭЭВЭРЛЭЛТЭД ТАВИХ ХЯНАЛТ

7.1. Зорчигч, тээш, ачаан тээш тээвэрлэлтэд хяналт тавих

7.1.1. Төмөр замын тээврийн аюулгүй байдал, тээвэрлэлттэй холбоотой ажил, үйлчилгээний чанар хууль тогтоомж, стандартын шаардлагад хангаж буй эсэхэд Төмөр замын тээврийн хяналтын улсын байцаагч хяналт тавина.

7.1.2. Хяналт тавих эрх бүхий этгээд нь Зорчигчдод үйлчлэх төв ба галт тэргэнд тасалбар худалдах ажлын зохион байгуулалт, зорчигчдын үйлчилгээнд илэрсэн алдаа дутагдлыг арилгуулах арга хэмжээ авна.

7.1.3. Төмөр замын тээврийн хяналтын улсын байцаагч болон төмөр замын байгууллагын эрх бүхий албан тушаалтан зорчигчийн галт тэргэнд шалгалт хийх эрхтэй.

НАЙМДУГААР БҮЛЭГ

ЗОРЧИГЧ ТЭЭВЭРЛЭЛТИЙН ТАРИФ БА НЭМЭГДЭЛ

8.1. Зорчигч тээвэрлэлтийн тариф

8.1.1. Төмөр замын тээврийн хууль болон орон тооны бус зөвлөлийн дүрэм, тариф тогтоох аргачлалын дагуу тээвэрлэгч тогтооно.

8.1.2. Төмөр замын тариф тогтоох аргачлалд өөрөөр заагаагүй бол тарифыг зөвхөн эхлэх болон хүрэх өртөө хоорондын тээвэрлэлтэд хэрэглэнэ.

8.1.3. Тасалбар худалдан авах үед төлбөрийг Тээвэрлэгчийн хүчин төгөлдөр мөрдөж байгаа тарифын дагуу тооцоолно.

8.1.4. Зорчигч тээш, ачаан тээшийн тарифийн үнийн өөрчлөлтийг хүчин төгөлдөр мөрдөхөөс 10-аас доошгүй хоногийн өмнө олон нийтийн мэдээллийн хэрэгслээр нийтэд зарлана.

ЕСДҮГЭЭР БҮЛЭГ

ДҮРЭМ ЗӨРЧИГЧДӨД ХҮЛЭЭЛГЭХ ХАРИУЦЛАГА

9.1. Тээвэрлэлтийн үүргээ зохих ёсоор биелүүлээгүй тохиолдолд үүсэх хариуцлагыг холбогдох хууль, энэхүү дүрэм болон тээвэрлэгч нарын хооронд байгуулсан гэрээний дагуу шийдвэрлэнэ.

9.2. Төмөр замын ажилтнууд энэхүү дүрэмд заасан хэм хэмжээг баримтлан эрх, үүргээ шударгаар хэрэгжүүлэх үүрэг хүлээнэ;

9.3. Төмөр замын байгууллага нь зорчигчийн тээш ба ачаан тээшийг хүлээж авснаас эхлэн олгох хүртэл тогтоосон дүрмийн дагуу тэдгээрийн бүрэн бүтэн байдлыг хариуцна.

9.4. Энэхүү дүрмийг зөрчсөн этгээдэд Төмөр замын тээврийн тухай хууль болон Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

9.5. Давагдашгүй хүчин зүйлийн нөлөөллөөс бусад тохиолдолд тээвэрлэгчийн буруугаас тээш, ачаан тээшийг хүргэх хугацаа хожимдуулсан бол тээвэрлэгч зорчигчийн өргөдлийг үндэслэн тээш, ачаан тээш ирэх хугацаа 24 цаг хэтэрсэн тохиолдолд түүнээс хойших хугацааны торгуулийг Иргэний хуулийн дагуу шийдвэрлэнэ.

---oOo---